Батлав.

Захирал ...../Г. Очирхуяг/

Цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөл: Дугаар № 317 /2017

2017 оны 12-р сарын 18 - ны өдөр Мөрөн сум

1. Техникийн нөхцөл хүссэн хэрэглэгчийн нэр: МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД. 17060Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр, Утас 62263051, Факс: (976) 70043479
2. Хэрэглэгчийн байршил: Хөвсгөл аймаг Мөрөн сум. 5-р баг
3. Ажил үйлчилгээний зориулалт: 5-р багийн гэрэлтүүлэг.
4. **Техникийн нөхцөл олгох үндэслэл**: МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД-ын 2018.02.09-ний өдрийн № а/556 тоотын дагуу
5. Суурилагдсан чадал 15 кВт.
6. Холбогдох цэг: Мөрөн 6 кВ-ын ХБ-ын "Дулаан-3" фидерийн АТП-13, АТП-15, КТПН-16 дэд өртөөнүүдийн 0.4 кВ-ын ерөнхий шитнээс ачаалалд тооцсон СИП кабелиар хэрэглээг тэжээх
7. Тоолуур: 3 фазын электрон тоолуур/DTSD-545 маркийн/
8. Гүйдлийн трансформатор: тооцоогоор сонгох
9. **Тусгай заалтууд: :** (Энэ дэд өртөө шугамыг өргөтгөх,шугамын трасс өөрчлөх, гадны хэрэглэгчийн шугамаас тэжээхэд тавигдах шаардлага болон шаардлагатай бусад заалтууд орно).
10. **Техникийн нөхцлийн хүчинтэй хугацаа:** 3 жил

Щит тоноглолын болон газардуулгыг норм дүрэм стандартын дагуу хийх

Дор дурьдсан техникийн даалгавар, хууль, дүрмийг мөрдөх:

Дээр өгөгдсөн холболт хийх цэгээс холбогдох дүрэм зааврын дагуу шугам татан авч, тоног төхөөрөмжийн газардуулгыгнорм стандартын дагуу хийн эрх бүхий байгууллагаар хэмжүүлэн акт гаргуулан авах

Кабель шугамын трасс, хамгаалалтын зурваст барилга барих, зам талбай засах, бетондохыг хориглоно.

Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар цахилгаан техникийн байгууламжийн дүрэм , аюулгүй ажиллагааны дүрэм , техник ашиглалтын дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.

Хүчдэлийн түвшингийн ±5%-ийн хэлбэлзэлд зохицсон тоноглол суурилуулах.

Засгийн газрын 2001 оны өдрийн 263 тоот тогтоолоор батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн заалтыг мөрдлөгө болгох.

Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээний зааг доторхи цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилох бөгөөд шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр , орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно. (Хэвийн бус үйл ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээ хийлгэх)

Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна.

Цахилгаан эрчим хүчний тооцоог сар бүрийн 20 -ны дотор хийх.Хэрэглэгч нь Эрчим хүчний тухай хуулийн 30.1.11-д заасны дагуу хүчин чадлын хүрээнд тус компанийн зөвшөөрлөөр шинээр хэрэглээг нэмэх бол зөвшөөрөл авч холбуулах үүрэгтэй.

Техникийн комиссын дарга.....Д.Отгонбаяр

Гишүүд.....Г.Даваадорж

.....Д.Нарантунгалаг